

ДҮГНЭЛТ

“Эгийн голын УЦС-ын дэд бүтэц” төслийн төлөвлөлтийн шийдэл, ажлын зураг төсөл, төсөл хэрэгжих орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн байдал, БОНБНУ боловсруулахад оролцсон шинжээчдийн судалгааны үр дүнд тулгуурлан төслийн барилгын ажлын үед болон төсөл хэрэгжих үед орчны байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийг доорхи байдлаар нэгтгэн дүгнэж байна.

Эерэг нөлөөлөл

Төсөл хэрэгжсэнээр дараахь эерэг нөлөөллийг үзүүлнэ. Үүнд:

- Барилгын ажлын үед ажлын түр байр бий болох ба үүнээс үүдэн орон нутгийн ард иргэдийн мэдлэг, боловсрол, амьдралын түвшин дээшилж, өрхийн эдийн засгаас эхлээд бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн өсөлт гарна.
- Төсөл хэрэгжсэнээр хатуу хучилттай авто зам тавигдаж дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх болно.
- Дэд бүтэц нь бүс нутгийн эдийн засагт чухал ач холбогдол өгнө. Ингэж эдийн засаг өссөнөөр тухайлан эмнэлгийн тусламж, эрүүл мэндийн үйлчилгээ, харилцаа холбоо, боловсролын системүүдэд ч эерэг нөлөөтэй байх юм.
- Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хийгдсэн байгаль орчны болон нийгэм, эдийн засгийн судалгаа, шинжилгээний ажлын мэдээ, мэдээлэл, удаан хугацааны турш хийгдсэн хяналт-шинжилгээний материал, үүний дотор ургамал, амьтны аймгийн судалгаа нь тухайн орон нутгийнхны мэдээллээр хангаад зогсохгүй бүс нутгийн хэмжээний чухал мэдээллийн баазтай болох сайн талтай.
- Төсөл хэрэгжих орчны ард иргэд дэд бүтэц түшиглэн жижиг дунд бизнес эрхлэн амжиргааны түвшин, өрхийн орлого нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжсэнээр хүрээлэн буй байгаль орчиндоо дараахь сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Үүнд:

- Барилгын ажлын үеэр их хэмжээний газрын гадарга, хөрс эвдэрнэ.
- Барилгын ажлын үе шатанд агаарт тоос шороо дэгдэн, машин механизмын утаа орчмыг бохирдуулна.
- Хог хаягдал, химийн бодисоор ус бохирдож болзошгүй.
- Барилгын ажлын үед нийт 240,0 орчим га талбайн хөрс, ургамлан нөмрөг газар шорооны ажлын үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрч доройтохоор байна.
- Барилгын талбай орчмын хөрсний биологи, химийн шинж чанарт өөрчлөлт орно. Машин механизмийн хөдөлгөөнөөс үүдэн хөрс эвдрэлд орно. Түүнчлэн машин машин, техник тоног төхөөрөмжөөс хөрсөнд хаягдах шатахуун, тос тослох материал, химийн бодис, техникийн хог хаягдал ба ахуйн хаягдлаар хөрс бохирдоно.
- Тодорхой хэмжээний бэлчээрийн талбайн ургамлын бүрхэвч талхлагдах ба ул хөрс тээвэрлэлтийн үед тоос шороо нь орчмын ургамлын бүрхэвчид сөрөг нөлөөлөл учруулна.
- Энэ орчимд 17 зүйлийн нэн ховор ургамал байна. Эдгээр ургамалуудын заримд дээрх сөрөг нөлөөлөл нөлөөлж болзошгүй.
- Төслийн талбай орчимд Монгол Улсын хэмжээнд хамгаалагдсан 8төрөл зүйлийн амьтан 4 зүйлийн шувуу тэмдэглэгдсэн байна. Мөн зэрлэг, онгон байгаль түүний дотор ан амьтдын амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх, хууль бус ан агнуур ихсэх, тэдгээрийн хоол тэжээл хомсдох ба нүүдлийн амьтдын нүүдийн замыг таслан зогсоох зэрэг нөлөөтэй.
- Төсөл хэрэгжих явцад хүн амын хөдөлгөөн ихсэнэ. Ингэснээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, аваар осол ихсэх, явуулын хүний тоо өсөн, улмаар халдварт өвчин үүний дотор бэлгийн замын халдварт өвчин ихсэж болзошгүй

- Төсөл хэрэгжин авто зам дагаад хүн ам шилжин суурьшиж, суурьшлын бүс бий болно. Үүнээс ахуйн хог хаягдлаар байгаль орчинд бохирдол үүсч нийгэмд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй.

Дээрхи дүгнэлтэд үндэслэн доорхи санал зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

- Барилгын ажлын үед болон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар үнэлгээний тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах;
- Энэхүү БОНБНУ-ий хүчинтэй байх хугацаанд (2014 он ... 2018 он) БОМТ-г удирдамж болгон жил бүрийн БОМТ-г боловсруулж холбогдох байгууллагаар баталгаажуулан мөрдөж тайлагнаж ажиллах;
- Барилгын ажлын үед болон төслийг хэрэгжүүлэх явцад орчны эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгөх
- Төсөл хэрэгжүүлэх явцад БО-ны болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн зөвлөмж, шаардлагын дагуу шуурхай арга хэмжээ авч дутагдал зөрчлийг тухай бүрд нь арилгаж үр дүнг нь тайлагнаж байх;
- Төсөл хэрэгжих орчны сум орон нутагтай хамтран байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Сум орон нутгийн байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй боловсон хүчнийг чадавхжуулахад туслах

Дээрхи санал зөвлөмжүүдийг мөрдөж ажилласан нөхцөлд байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, улс орны нийгэм эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх энэхүү төслийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна.